



**“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК**

*Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, бүртгэлийн программ,  
сургалтын итгэмжлэгдсэн байгууллага*  
Хаяг : Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Энхтайвны өргөн чөлөө,  
Саяон төв 602 тоот  
Утас : 99118571, 70157405  
Веб хуудас: [www.ubaudit.mn](http://www.ubaudit.mn)  
Имэйл : [uliastavanaudit@ubaudit.mn](mailto:uliastavanaudit@ubaudit.mn)

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

2022 оны 02 сарын 25 № 52/22

**“ДАВААНБУЛАГ” ХК-ийн  
УДИРДЛАГАД**

Бид “Даваанбулаг” ХК-ийн (цаашид “Компани” гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

**Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх зэрэг зүйлс багтана.

**Аудиторын үүрэг хариуцлага**

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгосон бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцооллыг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор компанийн санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЭЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигдах ёс зүйн шаардлагын дагуу Бид компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЭЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт найдаж байна.

**Хэрэглээний хязгаарлалт**

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэг өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

**Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан**

Түүнчлэн, санхүүгийн тайлан бэлтгэхдээ Монгол улсад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн журам, заавартай нийцэж байна

**“УЛИАСТАЙ ВАН АУДИТ” ХХК**

